

ХАСBАНК ХК

Сонирхлын зөрчилтэй хэлцэл баталсан талаарх мэдээлэл

Тухай бүр мэдээлэх мэдээлэл /маягт 3/	
Тайлагнах хугацаа	2023 оны 12 дугаар сарын 01-ний өдөр
Үнэт цаас гаргагчийн мэдээлэл	Нэр: ХасБанк ХК УБГД: 000289255 РД: 2578697 Үнэт цаасны код: MN00XAC05687 Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, СБД, Ерөнхий Сайд Амарын гудамж, ХасБанкны Төв Байр, ШХ 20А, 72 Утас: 75771888 И-мэйл: info@xacbank.mn Вэбсайт: www.xacbank.mn
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	Монголын хөрөнгийн бирж ТӨХК
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Банк, санхүүгийн салбар
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	1,052,700,000 ширхэг энгийн хувьцаа
Тухай бүр мэдээлэх мэдээллийг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	Бэлтгэсэн: Ц.Алтантуяа, ТУЗ-ийн ажлын албаны мэргэжилтэн Хянасан: Н.Мөнхцэлмэг, Хууль хариуцсан захирал бөгөөд ТУЗ-ийн нарийн бичгийн дарга
1. Сонирхлын зөрчилтэй хэлцэл баталсан талаарх мэдээлэл	
ХасБанк ХК ("Банк")-ийн ТУЗ-ийн 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн R-2023-74, R-2023-75, R-2023-76 дугаар тогтоолуудаар, Банкны ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороо болон Аудитын хорооны зөвлөмжийн дагуу, Банкны эрх бүхий албан тушаалтан, түүний холбогдох этгээд болон Банкны хувьцаа эзэмшигчийн холбогдох этгээдийн нийт 697,300,000 (зургаан зуун ерэн долоон сая гурван зуун мянга) төгрөгийн үнийн дүн бүхий 3 (гурав) хэлцлийг баталсан. Эдгээр бүх хэлцлүүд нь холбогдох хууль тогтоомж болон Банкны дотоод журамд нийцсэн болно.	

Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Н.Мөнхцэлмэг

Албан тушаал: Хууль хариуцсан захирал бөгөөд ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

Гарын үсэг:



Огноо: 2023 он 12 сар 01 өдөр

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ



2023. оны 11 сарын 30 өдөр

№ R-2023-74

Улаанбаатар хот

Холбогдох этгээдийн болон сонирхлын
зөрчилтэй хэлцлийг батламжлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дахь заалт, 81 дүгээр зүйлийн 81.4.4 дэх заалт, 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэг, Банкны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.9 дэх хэсэг, 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, ХасБанк ("Банк")-ны Төлөөлөн удирдах зөвлөл ("ТУЗ")-ийн 2023 оны 7 дугаар сарын 07-ны өдрийн R-2023-48 дугаар тогтоолоор батлагдсан Сонирхлын зөрчилтэй этгээд болон холбогдох этгээдтэй хэлцэл хийх журмын 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсэг болон ТУЗ-ийн 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн ээлжит хурлаар хэлэлцээд гарсан шийдвэрийг тус тус үндэслэн:

ТЭМДЭГЛЭХ нь:

1. Банкны ТУЗ-ийн Эрсдэлийн удирдлагын хороо ("ЭУХ") болон Аудитын хороо ("АХ") тус тус 2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн хурлаараа хэлэлцээд, Банкны хувьцаа эзэмшигчтэй холбогдох этгээдтэй хийсэн энэхүү тогтоолын хавсралтад заасан нөхцөл бүхий 100,000,000 (нэг зуун сая) төгрөгийн үнийн дүнтэй хэлцэл ("Холбогдох этгээдийн болон сонирхлын зөрчилтэй хэлцэл")-ийг батламжлах зөвлөмж ТУЗ-д хүргүүлсэн болохыг;
2. Холбогдох этгээдийн болон сонирхлын зөрчилтэй хэлцэл нь аливаа хөнгөлөлттэй нөхцөлгүй, банкны өдөр тутмын үйл ажиллагааны хүрээнд харилцагчдад санал болгож буй нөхцөлөөс илүү давуу тал олгоогүй болохыг ЭУХ болон АХ тус тус тодорхойлсон болохыг; мөн
3. ТУЗ нь ЭУХ болон АХ-ны өгсөн зөвлөмжийн дагуу Холбогдох этгээдийн болон сонирхлын зөрчилтэй хэлцлийг батламжлахыг дэмжсэн болохыг тус тус дурдав.

ТОГТООХ нь:

1. Холбогдох этгээдийн болон сонирхлын зөрчилтэй хэлцлийг хавсралтаар батламжилсугай.
2. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Гүйцэтгэх захирал Г.Цэвэгжавд үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



САНЖАЙ ГҮПТА

ХУУЛЬ ХАРИУЦСАН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Н.МӨНХЦЭЛМЭГ



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ



2023. оны 11 сарын 30 өдөр

№ R-2023-75

Улаанбаатар хот

Холбогдох этгээдийн болон сонирхлын
зөрчилтэй хэлцлийг батламжлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дахь заалт, 81 дүгээр зүйлийн 81.4.4 дэх заалт, 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэг, Банкны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.9 дэх хэсэг, 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, ХасБанк ("Банк")-ны Төлөөлөн удирдах зөвлөл ("ТУЗ")-ийн 2023 оны 7 дугаар сарын 07-ны өдрийн R-2023-48 дугаар тогтоолоор батлагдсан Сонирхлын зөрчилтэй этгээд болон холбогдох этгээдтэй хэлцэл хийх журмын 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсэг болон ТУЗ-ийн 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн ээлжит хурлаар хэлэлцээд, гарсан шийдвэрийг тус тус үндэслэн:

ТЭМДЭГЛЭХ нь:

1. Банкны ТУЗ-ийн Эрсдэлийн удирдлагын хороо ("ЭУХ") болон Аудитын хороо ("АХ") нь 2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн тус тусын хурлаараа хэлэлцээд, Банкны эрх бүхий албан тушаалтны холбогдох этгээдтэй хийсэн, энэхүү тогтоолын хавсралтад заасан нөхцөл бүхий 180,000,000 (нэг зуун наян сая) төгрөгийн үнийн дүнтэй зээл ("Холбогдох этгээдийн болон сонирхлын зөрчилтэй хэлцэл")-ийг батламжлах зөвлөмж ТУЗ-д хүргүүлсэн болохыг;
2. Холбогдох этгээдийн болон сонирхлын зөрчилтэй хэлцэл нь Ажилтны зээлийн ерөнхий журамд нийцсэн болохыг ЭУХ болон АХ тус тус тодорхойлсныг; мөн
3. ТУЗ нь ЭУХ болон АХ-ны өгсөн зөвлөмжийн дагуу Холбогдох этгээдийн болон сонирхлын зөрчилтэй хэлцлийг батламжлахыг дэмжсэн болохыг тус тус дурдав.

ТОГТООХ нь:

1. Холбогдох этгээдийн болон сонирхлын зөрчилтэй хэлцлийг хавсралтаар батламжилсугай.
2. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Гүйцэтгэх захирал Г.Цэвэгжавд үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



САНЖАЙ ГҮПТА

ХУУЛЬ ХАРИУЦСАН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТУЗ-ИЙН НАРИЙН БИГГИЙН ДАРГА

Н.МӨНХЦЭЛМЭГ



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ



20 23 оны 11 сарын 30 өдөр

№ R-2023-76

Улаанбаатар хот

Холбогдох этгээдийн болон сонирхлын
зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дахь заалт, 81 дүгээр зүйлийн 81.4.4 дэх заалт, 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэг, Банкны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.9 дэх хэсэг, 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, ХасБанк ("Банк")-ны Төлөөлөн удирдах зөвлөл ("ТУЗ")-ийн 2023 оны 7 дугаар сарын 07-ны өдрийн R-2023-48 дугаар тогтоолоор батлагдсан Сонирхлын зөрчилтэй этгээд болон холбогдох этгээдтэй хэлцэл хийх журмын 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсэг болон ТУЗ-ийн 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн ээлжит хурлаар хэлэлцээд, гарсан шийдвэрийг тус тус үндэслэн:

ТЭМДЭГЛЭХ нь:

1. Банкны ТУЗ-ийн Эрсдэлийн удирдлагын хороо ("ЭУХ") болон Аудитын хороо ("АХ") нь 2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн тус тусын хурлаараа хэлэлцээд, Банкны эрх бүхий албан тушаалтантай хийх, энэхүү тогтоолын хавсралтад заасан нөхцөл бүхий 417,300,000 (дөрвөн зуун арван долоон сая гурван зуун мянга) төгрөгийн үнийн дүнтэй зээл ("Холбогдох этгээдийн болон сонирхлын зөрчилтэй хэлцэл")-д зөвшөөрөл олгох зөвлөмж ТУЗ-д хүргүүлсэн болохыг;
2. Холбогдох этгээдийн болон сонирхлын зөрчилтэй хэлцэл нь Ажилтны зээлийн ерөнхий журамд нийцсэн болохыг ЭУХ болон АХ тус тус тодорхойлсныг; мөн
3. ТУЗ нь ЭУХ болон АХ-ны өгсөн зөвлөмжийн дагуу Холбогдох этгээдийн болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгохыг дэмжсэн болохыг тус тус дурдав.

ТОГТООХ нь:

1. Тогтоолын хавсралтад заасан Холбогдох этгээдийн болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрч баталсугай.
2. Хэлцлийн нөхцөлд аливаа материаллаг өөрчлөлт ороход ТУЗ-д дахин танилцуулж зөвшөөрөл авахыг үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



САНЖАЙ ГҮПТА

ХУУЛЬ ХАРИУЦСАН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Н.МӨНХЦЭЛМЭГ

